БАТЛАВ:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1 .

Хууль зүйн үндэслэл:

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.7, 2.1.2.10, 3.1.2.1, 3.2.2.3 дэх хэсгүүд болон “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн боловсруулсан болно.

1.2.Практик шаардлага:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн Албан татвар ногдуулах хувь хэсгийн **“**11.1.Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулна.” гэж хуульчилсан. Статистик мэдээллээс харахад Монгол улсын НӨАТ-ын орлого тасралтгүй өсч, далд эдийн засаг хумигдан төсвийн орлого нэмэгдэх сайн үр дүн байгаа хэдий ч энэ бүхний цаана орлого цуглуулах чадвар хэмээх үзүүлэлтээр хэмжигдэх үнэлгээний хэмжүүр байгааг анзаарах ёстой. Манай улсын татварын орлого цуглуулах чадварын үзүүлэлт маш өндөртэй боловч НӨАТ-ын буцаан олголт бага олгож байгаа нь НӨАТ-ын нэг гол зорилго болох татварын системийг сайжруулах зорилгоосоо илүү төсвийн орлогыг бүрдүүлэх тал дээр илүү ач холбогдол өгч байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын НӨАТ-ын орлого өсч үүнийг дагаад Орлого цуглуулах чадвар нэмэгдэж байгаа хэдийч үр дүнд нь инфляцийн түвшин болон ажилгүйдлийн түвшин өсөх, ДНБ буурах эрсдэл хэвээр байгаа төдийгүй аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дарамт болж байна.

НЭГ. НӨАТ төлөх аж ахуй нэгжийн тоо нэмэх

Нийт аж ахуй нэгж байгуулагуудаас хуулийн этгээд буюу компани, хоршоо гэх мэтийг салгаж харвал 250 мянга орчим байна. Эдний ердөө 36.9% нь л идэвхтэй үйл ажиллагаа явуулж, үлдсэн 63.1% нь үйл ажиллагаагаа эхлээгүй,

түр болон бүрэн үйл ажиллагаагаа зогсоосон байдалтай байна. Идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй 104.5 мянган этгээдийн 83% нь компани хэлбэрээр, үлдсэн нь ТББ, нөхөрлөл, хоршоо гэх мэт хэлбэртэй байна. Хуулийн этгээдүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь харвал дийлэнх буюу 40.7%-ийг нь үйлчилгээний салбар, хамгийн бага буюу 3.4%-ийг ХАА-н салбарынхан бүрдүүлжээ. Үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн 83% нь 1-9 ажилтантай бол ердөө 3% нь 50 ба түүнээс дээш ажилтантай аж. Түүнчлэн нийт идэвхтэй хуулийн этгээдэд 866 мянган хүн ажиллаж байгаа буюу 1 идэвхтэй хуулийн этгээдэд дунджаар 9.4 хүн л ажиллаж байна. Нийт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдээс орлого олдог 85 мянган орчим аж ахуй нэгж бий. 4 сая хүртэл орлоготой 17.2 мянган аж ахуй нэгж байхад 2.5 тэрбумаас дээш орлоготой ердөө 4.7 мянган аж ахуй нэгж байна. Улмаар уг 4.7 мянган компани нийт орлогын 86.6%-ийг дангаараа бүрдүүлдэг. Тэгэхээр бага орлоготой олон, арай их орлоготой цөөхөн хэдэн л компани байна.

ХОЁР. НӨАТ-ын хуульд байгаа зарим алдааг засварлах

Монгол Улсын 10000 иргэн улсын хилээр 100.0 тэрбум төгрөгийн барааг импортлон оруулж ирсэн гэж үзвэл 50.0 сая төгрөгөөс бага борлуулалтын орлоготой учраас НӨАТ тайлагнагч /төлөгч/ биш гэсэн ойлголт төрүүлэхээр байдаг. Гэтэл НӨАТ-ын хуулийн 9.3 дахь заалтаар 10000 иргэн бүгд НӨАТ төлөгч боловч НӨАТ-ын буцаан олголтын сангаас буцаан олголт авах эрхгүй нь тэдгээр иргэдийн борлуулалтын орлого 50.0(хуучин хуулиар 10.0 сая төгрөг) сая төгрөгт хүрдэггүйтэй холбоотой байдаг.

2022 оны байдлаар Татварын албанд НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн 50000 орчим иргэн, аж ахуйн нэгжүүд бий. Эдгээр татвар төлөгчид НӨАТ-ын орлогын 80 орчим хувийг бүрдүүлдэг. Хоёр дахь нь, НӨАТ төлөгч бус 300000 орчим иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогыг хянах бодлоготой бөгөөд олгосон баримтад нь НӨАТ бодогдож төлөгдөхгүй байгаа юм.

Иргэдийн нэрээр импортоор орж ирсэн барааны гааль дээр төлсөн НӨАТ нь улсын төсөвт шууд ордог боловч дээрх иргэд НӨАТ төлөгч биш гэсэн ангилалд хамаарагдан НӨАТ-ын буцаан авалтын сангаас хүртэх эрхгүй байсан.

Хуучин хуулиар Импортолсон бараа бүтээгдэхүүнийг худалдан авч цааш нь дамжуулан борлуулж байгаа этгээд болон үйлдвэрлэлдээ түүхий эд материал болгон хэрэглэж байгаа үйлдвэрлэгчид “анх тухайн барааг импортолсон иргэд нь НӨАТ-ын падан бичиж өгөөгүй” гэдэг үндэслэлээр тэдгээрийн гааль дээр төлөгдсөн НӨАТ-ын зардлыг өөрсдийн төлөх НӨАТ-аасаа хасч чаддаггүй. Иймд тухайн барааны гааль дээр төлөгдсөн НӨАТ дээр дахин НӨАТ-ын татвар нэмж улмаар 2 удаа давхардсан НӨАТ-тайгаар эцсийн худалдан авагчид борлуулагдаж тэдгээрийг давхар хохироосоор байна.

Энэхүү эрсдлээс хамаарч татвар төлөгчид НӨАТ-ын тайлан гаргахаас зайлсхийх, НӨАТ-ын хуурамч тайлан гаргах, эсвэл бусад жижиг нэгжийн НӨАТ-ыг өмнөөс нь төлж 2 талдаа татварын хөнгөлөлт эдлэх зэрэг хууль бус үйлдэл хийх нөхцөл бүрдээд байсан. Энэхүү эрсдлийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай шинэчилсэн хууль хэрэгжсэнээр бууруулж эхлээд байна.

Иймд дээрх эерэг үзүүлэлтийг улам гүнзгийрүүлэхийн тулд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн Албан татвар ногдуулах хувь хэсгийн **“**11.1.Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулна.” заалтын “… 10

хувиар ногдуулна.” гэснийг “… 5 хувиар ногдуулна.” гэж өөрчлөх, хуулийн хэрэгжилтийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэх санал гаргаж байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол улсын НӨАТ-ын систем тэр дундаа НӨАТ-ын Орлого цуглуулах чадварын үзүүлэлтийг сайжруулах болон татвар төлөгчдийн баазыг өргөтгөж, НӨАТ-ын хувь хэмжээг бууруулсанаар дээрх эрсдлүүдийг хязгаарлах боломж бүрдэх сайн талтай.

Энэхүү Хуулийн өөрчлөлт батлагдсанаар Орлого цуглуулах чадварын үзүүлэлт сайжирч, татвар төлөгчид НӨАТ-аа ил тод нээлттэй мэдээлж, тэдний бааз нэмэгдсэнээр хуулийн үйлчлэх хүрээ нэмэгдэн эдийн засагт болон татвар төлөгчдөд эерэг нөхцөл байдал бий болохоос гадна улсын төсөвт цугларах татварын орлого буурахгүй байх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар

Бидэнд НӨАТ-ын орлогын тоон дүнд нь бус чанарт анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлага гарч байна. НӨАТ-ын буцаан олголтыг зугуухан нэмэгдүүлсэнээр НӨАТ-ын орлого цуглуулах чадвар өсч инфляцийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ДНБ зэрэгт эерэг нөлөө үзүүлэх боломж их байгаа нь харагдаж байна. Иймд НӨАТ-ын орлогын тоон өсөлтөнд бус чанарт нь анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байгаа бөгөөд шийдвэр гаргагчид дараах арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд**:**

-Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн Албан татвар ногдуулах хувь хэсгийн **“**11.1.Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулна” заалтын “… 10 хувиар ногдуулна.” гэснийг “… 5 хувиар ногдуулна.” гэж нэн яаралтай өөрчлөх,

А. Нэмэгдсэн өртгийн албан татвар ба Эдийн засгийн харилцан хамаарал үр дагавар

Аливаа татвар нь эдийн засгийн зохицуулалтгүй бол нийт байгууллага, иргэдийн ажил болон амьжиргааны түвшинд шууд нөлөөлж байдаг эдийн засгийн онцгой төрлийн механизм юм. Эдийн засагт үнэ болон орлогын хуваарилалт нь нийтлэг нөлөөлдөг гол хүчин зүйлүүд болохын хувьд НӨАТ үүнд чухал үүрэгтэй. Төрийн хэрэгжүүлэгч байгууллага нь НӨАТ-ын орлого цуглуулах чадвар ба эдийн засгийн хамаарлыг тодорхойлохоос өмнө татвар төлөгчдийн бааз суурийг нэмэгдүүлэх үзүүлэлтийг тодорхойлох нь чухал ач холбогдолтойг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Б. НӨАТ-ын Орлого цуглуулах чадвар

Татварын орлого цуглуулах чадвар гэдэг нь тухайн татварыг нэвтрүүлснээр улс орон нутгийн төсөвт нэмж төвлөрөх татварын орлогын хэмжээг тодорхойлох хэмжигдэхүүн юм. Орлого цуглуулах чадварын үзүүлэлтийг тооцохдоо дараах аргаар тооцно. Үүнд:

$$\textbf{Орлого цуглуулах чадвар} = \frac{\text{НӨАТ-ын орлогын ДНБ-д эзлэх хувь}}{\text{НӨАТ-ын үндсэн хувь хэмжээ}} \times 100$$

Татварын орлого цуглуулах чадвар нь юуны түрүүнд татварын бааз суурь (татвар ногдох зүйл, хөнгөлөлт чөлөөлөлт), татвар төлөгчдийн тоо болон татварын хувь хэмжээнээс шууд хамаарна.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуультай бүрэн нийцэх боломжтой бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан 2020 оны Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг НӨАТ-ын тухай хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 5 хувиар татвар ногдуулах тухай заалттай нийцүүлнэ.

---oOo---